



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/50/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Энхчимэг
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Аудитор: Д.Мядагмаа
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.09.26 № 01/145
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨМӨРБУЛАГ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Д.МЭНДЖАРГАЛ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчилтэй зүйл илэрлээ. **Үүнд:**

Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 01 сарын 02-ны А/01 тоот тушаалаар Засгийн газрын 2022 оны "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолд заасан цалингийн хэмжээг нэмэгдүүлж 2023 оны 1-6 дугаар сард 18,871.3 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.", Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т "Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.", Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8-д "Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн

6724040313

41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах,” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөрчлийг материаллаг хэмжээний зөрчилд тооцсон бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг түвшнээс 7,583.2 мянган төгрөгөөр давсан.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотой “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам батлах тухай” ЭМДҮЗ-ийн 2022.03.23-ны 05 тоот тогтоол гарч, Эрүүл мэндийн байгууллагууд нэг иргэнээр тооцсон норматив зардлаар эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байна.

Үйл ажиллагааны орчинд бүтцийн өөрчлөлт гараагүй, дээрх тогтоолын дагуу Эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон зардлыг ЭМД-ийн сангаас өвчний оношийн төрлөөр, насны ангиллаар тогтоосон тарифт үндэслэн гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын цалингийн системд Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг буруу оруулсан түүнд тавих хяналт хангалтгүй байна. Үүнээс шалтгаалан тэтгэвэрт гарсан, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсний амралттай эх, хүүхэд асрах чөлөөтэй эхээс суутгасан нийгмийн даатгалын дүнд зөрүү үүссэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын дарга нь 2023 онд хэрэгжүүлж ажиллах гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө сумын Засаг даргаар 6 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж 90.1 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>261,337,994.42</u>	<u>213,803,121.95</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	134,948,413.08	91,658,474.36
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	134,948,413.08	91,658,474.36
3121	Төгрөг	134,948,413.08	91,658,474.36
31211	Төрийн сангийн харилцах	134,948,413.08	91,658,474.36
33	АВЛАГА	00.00	7,536,608.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	7,536,608.00
35	БАРАА МАТЕРИАЛ	126,389,581.34	114,608,039.59
351	Түүхий эд материал	68,929,575.05	58,285,943.80
35130	Эм боох материал	68,929,575.05	58,285,943.80
354	Хангамжийн материал	57,460,006.29	56,322,095.79
35410	Бичиг хэргийн материал	5,432,080.00	3,772,100.00
35420	Аж ахуйн материал	37,970,141.00	40,941,245.90
35430	Сэлбэг хэрэгсэл	300,000.00	00.00
35460	Хүнсний материал	8,563,486.84	8,248,951.44
35470	Бусад хангамжийн материал	5,177,798.45	3,359,798.45
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>688,428,395.83</u>	<u>692,085,280.21</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	688,428,395.83	692,085,280.21
392	Биет хөрөнгө	678,773,729.19	678,412,280.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	605,978,857.00	605,978,857.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(76,483,643.88)	(92,183,514.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	44,908,434.00	43,491,767.26
39204	Хуримтлагдсан элэгдэл	(28,555,139.37)	(35,139,878.21)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	150,596,386.92	162,370,692.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(57,455,052.05)	(70,855,446.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,073,269.93	24,154,269.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,910,693.76)	(11,402,097.24)
39209	Зам, гүүрийн байгууламж	22,270,444.00	22,270,444.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(6,681,133.44)	(7,794,655.68)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	20,000,000.00	20,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	160,000.00	18,077,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(128,000.16)	(555,158.33)
393	Биет бус хөрөнгө	9,654,666.64	13,672,999.94
39301	Програм хангамж	595,000.00	5,195,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(198,333.36)	(780,000.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,258,000.00	9,258,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>949,766,390.25</u>	<u>905,888,402.16</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>7,352,809.25</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,352,809.25	00.00

Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

413	Өглөг	7,352,809.25	00.00
4136	Бусад өглөг	7,352,809.26	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	7,352,809.26	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>942,413,581.00</u>	<u>905,888,402.16</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	942,413,581.00	905,888,402.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	663,406,697.28	663,406,697.28
51101	Өмч: - төрийн	663,406,697.28	663,406,697.28
512	Хуримтлагдсан үр дүн	108,011,242.69	71,486,063.85
51210	Өмнөх үеийн үр дүн	70,151,014.88	70,151,014.88
51220	Тайлант үеийн үр дүн	37,860,227.81	1,335,048.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	170,995,641.03	170,995,641.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>949,766,390.25</u>	<u>905,888,402.16</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	743,369,454.00	849,545,611.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,285,484.00	61,588,913.47
120	Нийтлэг татварын бус орлого	52,285,484.00	61,588,913.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	42,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	42,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	691,083,970.00	787,956,698.49
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,737,000.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	878,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	859,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,871,600.00	44,559,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,871,600.00	44,559,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	648,475,370.00	743,396,898.49
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	648,475,370.00	743,396,898.49
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	705,509,226.19	885,162,457.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	705,509,226.19	885,162,457.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	705,328,981.19	885,162,457.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	378,931,786.57	549,355,920.79
210101	Үндсэн цалин	237,255,690.83	343,578,023.47
210102	Нэмэгдэл	76,218,404.67	132,441,761.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,131,000.00	4,745,500.01
210104	Урамшуулал	51,113,595.07	62,714,925.86
210105	Гэрээт ажлын хөлс	10,213,096.00	5,875,710.00

Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,534,053.55	67,668,314.43
210201	Тэтгэврийн даатгал	32,419,158.47	45,771,974.37
210202	Тэтгэмжийн даатгал	3,377,953.26	5,477,958.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,914,301.22	4,366,881.58
210204	Ажилгүйдлийн даатгал	709,560.08	1,095,580.84
210205	Эрүүл мэндийн даатгал	7,113,080.52	10,955,919.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,326,991.26	37,368,908.74
210301	Гэрэл, цахилгаан	1,722,413.69	2,993,587.11
210302	Түлш, халаалт	33,604,577.57	34,375,321.63
2104	Хангамж, бараа материалын зардал	35,882,261.76	49,010,814.00
210401	Бичиг хэрэг	7,041,040.00	11,167,380.00
210402	Тээвэр, шатахуун	20,341,700.00	23,180,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,344,972.80	3,136,971.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,954,548.96	11,325,913.00
2105	Нормативт зардал	125,855,341.62	104,388,826.96
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	115,449,695.32	85,997,846.56
210502	Хоол, хүнс	10,405,646.30	18,390,980.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,741,200.00	19,235,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	2,376,000.00
210604	Урсгал засвар	14,741,200.00	16,859,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,776,000.00	2,179,600.00
210702	Дотоод албан томилолт	1,776,000.00	2,179,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,336,385.00	2,134,978.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,351,575.00	456,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	325,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	129,110.00	121,010.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	34,000.00
210807	Газрын төлбөр	35,700.00	21,968.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,944,961.43	53,820,094.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,143,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,801,961.43	53,820,094.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	180,245.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	180,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	180,000.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	245.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	245.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	37,860,227.81	-35,616,845.50
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	525,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	525,000.00

Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-525,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	37,860,227.81	-36,141,845.50

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	750,623,770.00	780,462,090.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	42,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	42,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	42,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	42,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	750,623,770.00	780,420,090.49
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,737,000.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	878,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	859,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,871,600.00	44,559,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,871,600.00	44,559,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	708,015,170.00	735,860,290.49
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	708,015,170.00	735,860,290.49
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	601,744,407.92	803,282,029.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	601,744,407.92	803,282,029.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	601,544,162.92	803,282,029.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	378,267,687.92	549,355,920.78
210101	Үндсэн цалин	236,591,592.18	343,578,023.47
210102	Нэмэгдэл	76,218,404.67	132,441,761.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,131,000.00	4,745,500.00
210104	Урамшуулал	51,113,595.07	62,714,925.86
210105	Гэрээт ажлын хөлс	10,213,096.00	5,875,710.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,947,949.86	67,668,314.43
210201	Тэтгэврийн даатгал	32,303,630.86	45,771,974.37
210202	Тэтгэмжийн даатгал	3,664,400.00	5,477,958.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,931,400.00	4,366,881.58
210204	Ажилгүйдлийн даатгал	733,000.00	1,095,580.84
210205	Эрүүл мэндийн даатгал	7,315,519.00	10,955,919.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,934,600.00	44,559,800.00
210301	Гэрэл, цахилгаан	1,722,413.69	2,993,587.11
210302	Түлш, халаалт	36,212,186.31	41,566,212.89
2104	Хангамж, бараа материалын зардал	32,248,972.80	31,801,521.00
210401	Бичиг хэрэг	2,092,000.00	2,215,500.00

Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	20,341,700.00	22,575,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,414,972.80	3,046,971.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	415,000.00	1,713,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,985,300.00	2,250,000.00
2105	Нормативт зардал	65,484,177.34	64,693,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,604,937.34	47,368,700.00
210502	Хоол, хүнс	15,920,640.00	17,325,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,958,600.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,958,500.00	25,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,667,500.00	00.00
210604	Урсгал засвар	6,291,000.00	25,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,776,000.00	2,179,600.00
210702	Дотоод албан томилолт	1,776,000.00	2,179,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,874,585.00	4,013,978.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,461,575.00	536,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	325,000.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	129,110.00	121,010.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	34,000.00
210807	Газрын төлбөр	35,700.00	21,968.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,428,200.00	1,799,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,051,690.00	14,009,195.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,051,690.00	14,009,195.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,245.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	245.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>148,879,362.08</u>	<u>(22,819,938.72)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,316,500.00	20,470,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,316,500.00	20,470,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,316,500.00	20,470,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,316,500.00	20,470,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(14,316,500.00)</u>	<u>(20,470,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	134,562,862.08	-43,289,938.72
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	385,551.00	134,948,413.08
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	134,948,413.08	91,658,474.36

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	663,406,697.28	170,995,641.03	(100,294,498.89)	734,107,839.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	129,138.00	129,138.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	663,406,697.28	170,995,641.03	(100,165,360.89)	734,236,977.42
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(12,708,787.15)	(12,708,787.15)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	663,406,697.28	170,995,641.03	108,011,242.69	942,413,581.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	663,406,697.28	170,995,641.03	108,011,242.69	942,413,581.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(36,141,845.50)	(36,141,845.50)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	663,406,697.28	170,995,641.03	71,869,397.19	906,271,735.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	922,833,700.00	823,752,029.21	99,081,670.79	89%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	922,833,700.00	823,752,029.21	99,081,670.79	89%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	922,833,700.00	823,752,029.21	99,081,670.79	89%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	630,370,700.00	549,355,920.78	81,014,779.22	87%
210101	Үндсэн цалин	426,096,600.00	343,578,023.47	82,518,576.53	81%
210102	Нэмэгдэл	127,416,400.00	132,441,761.45	(5,025,361.45)	104%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,536,000.00	4,745,500.00	(209,500.00)	105%
210104	Урамшуулал	63,619,500.00	62,714,925.86	904,574.14	99%
210105	Гэрээт ажлын хөлс	8,702,200.00	5,875,710.00	2,826,490.00	68%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,211,900.00	67,668,314.43	11,543,585.57	85%
210201	Тэтгэврийн даатгал	53,863,800.00	45,771,974.37	8,091,825.63	85%
210202	Тэтгэмжийн даатгал	6,337,100.00	5,477,958.61	859,141.39	86%
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,069,700.00	4,366,881.58	702,818.42	86%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,267,400.00	1,095,580.84	171,819.16	86%
210205	Эрүүл мэндийн даатгал	12,673,900.00	10,955,919.03	1,717,980.97	86%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,559,800.00	44,559,800.00	0.00	100%
210301	Гэрэл, цахилгаан	3,500,000.00	2,993,587.11	506,412.89	86%
210302	Түлш, халаалт	40,559,800.00	41,566,212.89	(1,006,412.89)	102%

Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	500,000.00	00.00	500,000.00	0%
2104	Хангамж, бараа материалын зардал	34,416,000.00	31,801,521.00	2,614,479.00	92%
210401	Бичиг хэрэг	2,250,000.00	2,215,500.00	34,500.00	98%
210402	Тээвэр, шатахуун	24,976,000.00	22,575,550.00	2,400,450.00	90%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,140,000.00	3,046,971.00	93,029.00	97%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	1,713,500.00	86,500.00	95%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,250,000.00	2,250,000.00	0.00	100%
2105	Нормативт зардал	67,735,400.00	64,693,700.00	3,041,700.00	96%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	47,368,700.00	47,368,700.00	0.00	100%
210502	Хоол, хүнс	20,366,700.00	17,325,000.00	3,041,700.00	85%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,470,000.00	45,470,000.00	0.00	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,500,000.00	10,500,000.00	0.00	100%
210602	Тавилга	9,970,000.00	9,970,000.00	0.00	100%
210604	Урсгал засвар	25,000,000.00	25,000,000.00	0.00	100%
2107	Томилолт, зочны зардал	2,700,000.00	2,179,600.00	520,400.00	81%
210702	Дотоод албан томилолт	2,700,000.00	2,179,600.00	520,400.00	81%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,358,200.00	4,013,978.00	344,222.00	92%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	742,700.00	536,000.00	206,700.00	72%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00	0.00	100%
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	350,000.00	0.00	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	121,010.00	28,990.00	81%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	34,000.00	32,000.00	52%
210807	Газрын төлбөр	66,000.00	21,968.00	44,032.00	33%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,831,500.00	1,799,000.00	32,500.00	98%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14011700.00	14009195.00	2,505.00	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,011,700.00	14,009,195.00	2,505.00	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	922,833,700.00	780,462,090.49	142,371,609.5	85%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	44,559,800.00	44,559,800.00	0.00	100%
132001	Орон нутгийн төсвөөс	44,559,800.00	44,559,800.00	0.00	100%
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	743,325,500.00	735,860,290.49	7,465,209.51	99%
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	743,325,500.00	735,860,290.49	7,465,209.51	99%

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	134,948,400.00	42,000.00	134,906,400.0	0%
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	42,000.00	(42,000.00)	0%
120004 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	134,948,400.00	00.00	134,948,400.0	0%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	134,948,413.08	(134,948,413.1)	0%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	91,658,474.36	(91,658,474.36)	0%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00	0.00	100%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	0.00	100%
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00	100%

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 35,820.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 15903.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 18,871.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,045.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулагдаагүй 5 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 25,820.2 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 11,288.1 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант онд хийгдсэн 10,000.0 мянган төгрөгийн нийгэм эрүүл мэндийн зардал бүхий биет бус хөрөнгийг бүртгэж авсан.
- Нийгмийн даатгалын тайлан, ХХОАТатварын тайлан зөрүүтэй 5,903.1 мянган төгрөгийг залруулсан.

3.1 Төлбөрийн акт

1. Цалингийн данстай холбоотой

Илрүүлэлт: ЭМТ-ийн даргын 2023 оны 01 сарын 02-ны А/01 тоот тушаалаар ажилчдын үндсэн цалинг нэмэгдүүлсэн нь ЗГ-ын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолд заасан цалингийн хэмжээг нэмэгдүүлж 2023 оны 1-6 дугаар сард 18,871.3 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь *Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.”, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т “Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.”, Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8-д “Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж,*

албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.” Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах,” гэж заасныг тус тус зөрчсөн ба “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Томилолтын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2023 оны томилолтын тооцоог мөнгөн хөрөнгийн анхан шатны баримттай тулгахад томилолтын зардалтай 6 хүнд 33.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгосон. Энэ нь “Төсвийн тухай хуулийн” 16 дугаар зүйлийн 16.5.2 батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих гэсэн заалт болон “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгөд тавих хяналтаа сайжруулах, цаашид алдааг давтахгүй байх.

2. Цалин, НДШ-ийн зардалтай холбоотой

Илрүүлэлт: Тэтгэвэрт гарсан ажилтныг Нийгмийн даатгалын тайланд 22 кодоор тайлагнасан ч цалингаас суутгах суутгалаа 9.3% биш 11.5%- иар бодон суутгасан. Үүнээс үүдэн 2 ажилтнаас нийт 1,012.8 төгрөгийг илүү суутган авсан байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн” 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” 17.1.3 “Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах” гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн системийн шимтгэлийн хувийг хянан тулгалт хийж байх.

3. Зардалтай холбоотой

Илрүүлэлт: Жолоочийн тооцоо бодож акт үйлдсэн эсэхийг анхан шатны баримтаас шалгахад тооцооны хуудсыг зөрүүтэй үйлдсэн байгаа нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан “Жишиг норм батлах тухай” журамд заасан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд “Иж бүрэн байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг холбогдох журмын дагуу бөглөж, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан “Жишиг норм батлах тухай” журамд заасан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг мөрдөж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмж, төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд хийгдсэн Нийгэм эрүүл мэндийн зардал бүхий биет бус хөрөнгийг бүртгэж аваагүй	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.0		
Нийгмийн даатгалын тайлан болон ХХОАТ-ын тайлан 2 зөрүүтэй дүнгээр тайлагнагдсан	1	5,903.1			1	5,903.1	1	5903.1		
Дүн	2	15,903.1			2	15,903.1	2	15,903.1		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭМТ-ийн даргын 2023 оны 01 сарын 02-ны А/01 тоот тушаалаар ажилчдын үндсэн цалинг нэмэгдүүлсэн нь ЗГ-ын 2022 оны 107-р тогтоолын 1 дүгээр хавсралттай нийцэхгүй байна	1	18,871.3	1	18,871.3				
2023 оны томилолтын тооцоог мөнгөн хөрөнгийн анхан шатны баримттай тулгахад томилолтын зардалтай 6 хүнд 33.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгосон.	1	33.0					1	33.0
Тэтгэвэрт гарсан ажилтныг Нийгмийн даатгалын тайланд 22 кодоор тайлагнасан ч цалингаас	1	1,012.8					1	1,012.8

Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

суутгах суутгалаа 9.3% биш 11.5%-иар бодон суутгасан. Үүнээс үүдэн 2 ажилтнаас нийт 1,012.8 мянган төгрөгийг илүү суутган авсан байна.								
Жолоочийн тооцоо бодож акт үйлдсэн эсэхийг анхан шатны баримтаас шалгахад тооцооны хуудсыг зөрүүтэй үйлдсэн байна	1	0.0					1	0.0
Дүн	4	19,917.1	1	18,871.3			3	1,045.8

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1					1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1					1		



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 56/А2270439/ХӨА-2024/50
НА-СТА-ТШЗ

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 01 дугаар сарын 02-ны А/01 тушаалаар Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолоор тогтоосон цалингийн хэмжээг нэмэгдүүлж 2023 оны 1-ээс 6 дугаар сард 18,871,267.62 /арван найман сая найман зуун далан нэг мянга хоёр зуун жаран долоон төгрөг жаран хоёр мөнгө/ төгрөгийн илүү цалинг албан хаагчдад олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно”, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-т “Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно”, Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 8-д “Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Үндэслэлгүйгээр цалин нэмэгдүүлэн олгосон 18,871,267.62 /арван найман сая найман зуун далан нэг мянга хоёр зуун жаран долоон төгрөг жаран хоёр мөнгө/ төгрөгийг төлбөрийн актын хавсралтад заасан албан хаагчдаар буцаан

6724020183

төлүүлж, Хөвсгөл аймгийн Төрийн сангийн 100170000955 /Хө.Бусад нэр заагдаагүй орлого/ тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Мэнджаргал, нягтлан бодогч М.Энхбат нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Ч.ЭНХЧИМЭГ



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
2024 оны дугаар сарын -ны өдрийн
.....
төлбөрийн актын хавсралт



Илүү олгосон цалингийн жагсаалт

/төгрөгөөр/

№	Овог	Нэр	Албан тушаал	Үндсэн цалингийн зөрүү
1	Дашбямба	Өнөрсайхан	Сантехникч	403,825.0
2	Магнайбаяр	Азбилэг	Нярав	1,202,372.0
3	Мишигдорж	Энхбат	Нягтлан бодогч	1,167,121.0
4	Балжинням	Баасанчулуун	Жолооч	745,130.0
5	Дашбалжир	Нэргүй	Тогооч	1,196,575.0
6	Балхаа	Баянмөнх	Вакциннатор	1,373,558.0
7	Төвд	Зүмбэрэлдорж	Т/сувилагч	745,130.0
8	Амраа	Оюунчимэг	Сувилагч	863,714.0
9	Ганбаатар	Эрдэнэчимэг	Сувилагч	863,714.0
10	Сүрэнжав	Оюунсүрэн	Т/сувилагч	188,518.3
11	Магнайбаяр	Өнөрцэцэг	Т/сувилагч	745,130.0
12	Цэгмид	Отгонбаяр	Бага эмч	949,260.0
13	Жамьяншарав	Баянмөнх	Бага эмч	1,373,558.0
14	Санжсүрэн	Баянжаргал	Их эмч	998,577.0
15	Ламжав	Мөнхбат	Бага эмч	949,260.0
16	Содномбалжир	Болорсайхан	Эх баригч бага эмч	770,570.2
17	Баяндалай	Баяржаргал	Лаборант	949,260.0
18	Батцэнгэл	Амаржаргал	Бага эмч	981,811.0
19	Дагвадорж	Мэнджаргал	ЭМТ-ийн дарга	1,405,649.0
20	Баянжаргал	Рагчаасүрэн	Их эмч	998,535.0
Нийт				18,871,267.6

oooOooo